



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/144

Ховд

Өвөлжилт хүндэрсэн сумдын малчин өрхүүдэд  
олгох тусламжийн хүнсний бараа хүлээн авах,  
хүргүүлэх ажлыг зохион байгуулах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хэрэгжиж буй "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл /Нэмэлт санхүүжилт"-ийн хүрээнд тусламжийн хүнсний барааг малчин өрх болон отроор яваа малчин өрхөд хүргүүлэх ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Онцгой байдлын газрын Улсын нөөцийн салбар агуулахын бэлэн байдлыг ханган тээвэрлэгдэн ирсэн хүнсний барааны аюулгүй байдлыг хянан шалгаж хүлээж авах, бүртгэх, буулгах, хадгалах, сумдад хүргэх ажлыг комиссын дарга /Б.Бямбажав/, Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа /Б.Алтанбадралт/ нарт даалгасугай.

3. Тусламжийн хүнсний барааг сумандаа татан авч малчдад хүргүүлэх ажлыг зохион байгуулах удирдамжийн хэрэгжилтийг 04 дүгээр сарын 01-ний дотор тайлагнахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Тусламжийн хүнсний барааг малчдад хүргүүлэхэд шаардлагатай арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/, Онцгой байдлын газрын дарга /Б.Алтанбадралт/ нарт зөвлөсүгэй.

5. Тусламжийн хүнсний барааг малчдад хүргүүлэх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 0918  
Zax A/144 Ch

Аймгийн Засаг даргын 2021 оны  
03 дугаар сарын 23-ны өдрийн  
А/144 дүгээр захирамжийн хавсралт

ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭН МАЛЧИН ӨРХҮҮДЭД  
ТУСЛАМЖИЙН ХҮНСНИЙ БАРАА ХҮРГҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга : Б.Бямбажав -Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд:

Б.Гантулга -Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

С.Шүрхүү -Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
Мал үржлийн албаны мэргэжилтэн

Г.Нэргүй -Баруун бүсийн Онцгой байдлын  
газрын дэд дарга д/х/

Т.Сумьяа -Онцгой байдлын газрын нярав

Нарийн бичгийн  
дарга: Д.Мөнхжаргал -Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр  
худалдаа, үйлчилгээний албаны  
мэргэжилтэн

-оОо-